



## Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын анхдугаар Үндэсний чуулганаас гаргасан зөвлөмж

**2015.11.05**

Монгол Улсын Засгийн газар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ыг 2006 оноос хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлж байна. ОУИТБС-д нэгдэн орсон цагаасаа манай улс энэхүү санаачилгын хүрээнд тавигдаж буй бүхий л стандарт, шаардлагыг бүрэн хангаж, энэ үзүүлэлтээрээ санаачилгыг хэрэгжүүлэгч дэлхийн 51 орны 4 дүгээрт, ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны даргын нэрэмжит шагналыг 2 удаа хүртсэн анхдагч улс болсон билээ.

Гэсэн хэдий ч ОУИТБС-ыг хэрэгжүүлснээр манай улсын нийгэм, эдийн засагт гарч буй үр нөлөө, бэрхшээл, сургамжийг олон талын оролцоотойгоор хэлэлцэж, нэгдсэн ойлголтонд хүрэх зорилгоор ОУИТБС-ын анхдугаар Үндэсний чуулганыг 2015 оны 11 сарын 3, 4-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

Чуулганд төр засаг, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчид, судлаачид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй, 13 аймаг, 11 сумын нутгийн удирдлага, иргэдийн хурлын тэргүүлэгчид зэрэг нийт 250 гаруй зочид, төлөөлөгчид оролцлоо. Мөн “Төлснөө Нийтэл” иргэний нийгмийн олон улсын сүлжээний Евро-азийн бүсийн төлөөлөгчид оролцож, туршлага мэдээлэл хуваалцсан юм.

Ийнхүү 2 өдөр чуулж, оролцогч талуудын тодорхойлсоноор Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн, ололт амжилтыг дурьдвал:

- ОУИТБС-ын нэгдсэн тайлан 9 жил дараалан гаргаж, тайлангийн чанар, агуулга сайжирч, мэдээллийн бааз үүссэн
- Сүүлийн 3 жил Засгийн газар олборлох салбараас олсон бүх орлогоо компани бүрээр гаргаж байна
- Цахим тайлагналын систем нэвтрүүлж, тайлан гаргах үйл явцыг хялбаршуулж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн
- Төр засгийн зүгээс эрдэс баялгийн салбар дахь эрх зүйн орчинг сайжруулж, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогоо тодорхойлж, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн хураамжаас улсын төсөвт орох орлогын 30%-ийг сум, орон нутагт нь шууд хуваарилах, орон нутгийн хөгжлийг дэмжихэд зориулах зохицуулалтыг Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан нь орон нутагт хүлээн авах орлогыг нэмэгдүүлсэн байна.
- Үндэсний түвшинд төр, компани, иргэний нийгмийн тэгш оролцоо хангагдаж, харилцан итгэлцэл бий болсон

- Иргэний нийгмийн байгууллагууд ОУИТБС-ын үйл явцад хяналт тавих, мониторинг үнэлгээ хийх, нөлөөллийн ажил зохион байгуулах, сургалт хийх, мэдээлэл түгээх зэргээр өргөн хүрээнд үр дүнтэй оролцож ирсэн

Гэсэн хэдий ч эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангахад тулгамдаж буй асуудлууд, бэрхшээл байсаар байна. Үүнд:

- Бодлого тодорхойлох түвшинд ялангуяа УИХ болон орон нутгийн ИТХ-ын түвшинд ОУИТБС-ын тайлан мэдээллийг ашиглахгүй байгаа нь ОУИТБС-д төрийн байгууллагуудын шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудын оролцоо хангалтгүй байхад нөлөөлж байна.
- 2012 оноос олборлох үйлдвэрлэл эрхлэгч, компаниудын ОУИТБС-ын тайлан гаргах идэвх буурч байгаа нь ихээхэн санаа зовоосон асуудал болж байна.
- ОУИТБС-ын жил бүрийн нэгтгэл тайланг шуурхай гаргах, мэдээллийг түүх болголтгүй хурдан шуурхай олон нийтэд хүргэх талаар зохистой арга хэмжээ авч чадахгүй байгаа нь ОУИТБС-ын тайлангийн ач холбогдолыг бууруулахад нөлөөлж байна.
- ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх үүрэг бүхий дэд зөвлөлийн үүрэг, оролцоо, хариуцлагын тогтолцоо тодорхойгүй, санхүүжилт дутмаг байдал ОУИТБС-ын үндэсний хэмжээнд салбарын засаглалыг сайжруулах хэрэгсэл болох үндсэн үүргээ хангаж чадахгүйд хүргэж байна.
- ОУИТБС-ын тайлан дахь мэдээллийг хэрхэн ашиглах талаар олон нийт ойлголтгүй, арга зүй дутмаг, орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын чадавх сул байгаад дүгнэлт хийж оролцоог сайжруулах талаар бодитой ажил хийгдэхгүй, төсөв хөрөнгө зарцуулахгүй байна.

Иймд ОУИТБС-ын анхдугаар Үндэсний чуулганы олон талт оролцогчид Монгол Улс дахь ОУИТБС-ын хэрэгжилт, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн 2020 он хүртэлх дунд хугацааны стратегийн баримт бичигт тусгах арга хэмжээний талаар олон санал, санаачлага гаргасныг үүгээр баталгаажуулан, холбогдох байгууллагуудад **ЗӨВЛӨМЖИЛЖ байна:**

### **УИХ, Хууль тогтоогч нарт**

- Эрдэс баялгийн салбартай холбоотой аливаа хууль, тогтоомж, шийдвэр гаргахдаа Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын нэгтгэл тайлан дахь мэдээллийг суурь судалгаа болгож ашигладаг байх
- Төр засгийн өндөр албан тушаалтнууд, бодлого тодорхойлогчид ОУИТБС-ын хэрэгжилтэнд идэвхтэй оролцож, байгалийн баялгаас олсон орлогоо ирээдүйн төлөө үр ашигтай зарцуулж, түүнээс бүх нийтийн хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх
- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах тухай хуулийн төслийг шинэчлэн сайжруулж, яаралтай хэлэлцэн батлах
- ОУИТБС-ыг Нээлттэй засаглалын түншлэл, Шилэн данс, Төсвийн тухай хуулийн шинэчлэл, төрийн бусад бодлоготой уялдуулан хэрэгжилтийг үр дүнтэй хангах
- Иргэний нийгэм шийдвэр гаргах түвшинд оролцдог байх эрх зүйн орчинг бүрдүүлэх
- ОУИТБС-ын дэд зөвлөлийг үр дүнтэй ажиллах чиг үүрэг, санхүүгийн орчныг бүрдүүлж баталгаажуулах

### **Засгийн газар, хэрэгжүүлэгч агентлаг нарт**

- ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт төрийн байгууллагуудын шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудын оролцоог тогтвортой хангах, тухайн ажилтаны ажил үүргийн хуваарьт албан ёсоор оруулах
- Засгийн газрын жил бүрийн ОУИТБС-ын тайланд Үндэсний аудитын газар баталгаажуулалт хийж, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах
- Олборлох салбараас олж буй орлогын урсгалыг бүртгэдэг төрийн байгууллагуудын программыг уялдуулах, тайлан гаргах үйл явцыг хөнгөвчлөх
- ОУИТБС-ын тайлангаа гаргаагүй эсхүл буруу тайлагнасан төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу хариуцлага тооцох, хариуцлагын тогтолцоог сайжруулах
- Аймгийн Аудитын газрын чадавхийг бэхжүүлэх замаар жил бүрийн ОУИТБС-ын нэгтгэл тайланд хамрагддаггүй жижиг, дунд компанийн тайланг тулган баталгаажуулах
- ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх дэд зөвлөлийн чиг үүргийг шинэчлэн батлаж, Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолыг шинэчлэх, аймаг нийслэл, сум дүүргийн засаг даргын үр дүнгийн гэрээнд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаар тодорхой нэг чиг үүрэг болгож оруулах

### **Мэргэжлийн холбоод, компаниудын удирдлага нарт**

- Нийгмийн хариуцлагын MNS:26001 стандартыг мөрдөж ажиллах, олон нийтэд сурталчилах
- Компаниудын ОУИТБС-ын тайлан гаргах хуульчилсан үүргийн хэрэгжилтийг хангуулах, тайлан гаргах ирцийг 100 хувьд хүргэх
- Жижиг, дунд компаниудын цахим тайлан гаргах чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх
- Компаниуд жил бүрийн ОУИТБС-ын тайландаа аудит хийлгэж, тайлагнасан мэдээлэл нь алдаагүй болохыг баталгаажуулж, аудитын захидал хавсаргах
- Эрдэс баялгийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшиж буй бүх компаниуд “Ил тод байдлын” тайлангаа тогтмол гаргаж хэвших, тайлан дахь мэдээлээ үйл ажиллагаа явуулж буй сум, орон нутгийн иргэддээ мэдээлж ажиллах

### **Иргэний нийгмийн эвсэл, холбоод, төрийн бус байгууллагуудад**

- Эрдэс баялгийн салбарын засаглалыг сайжруулах зорилго, үйл ажиллагаа бүхий төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн эвсэл, холбоод, идэвхтэй иргэд ОУИТБС-ын үйл явцад идэвхтэй оролцож, тайлан дахь мэдээллийг ашиглан хяналтаа сайжруулах, олон нийтийн дуу хоолой болох
- Иргэний нийгмийн байгууллагуудын бие даасан, хараат бус ажиллахад саад болж буй хүчин зүйлсийг судлаж, шийдвэрлэх арга замыг боловсруулан Үндэсний зөвлөлийн хурлаар жилд нэг удаа хэлэлцүүлж зохих шийдвэрийг гаргаж хэрэгжүүлдэг байх

- Орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх төрөл бүрийн арга хэмжээ авч хүчин чармайлтаа үргэлжүүлэх
- ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүрээнд зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх чадавхаа нэмэгдүүлэх
- ОУИТБС-ын тайланг олон нийтэд хүргэхэд хамтарч ажиллаж, орон нутагт нээлттэй өдөрлөг, уулзалт зохион байгуулах төрөл бүрийн арга зүй боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, Үндэсний зөвлөлийн хуралд жилд нэг удаа үйл ажиллагаагаа тайлагнадаг байх
- ОУИТБС-ын хэрэгжилтэнд хяналт тавьж, авилга буурсан эсэх, засаглал сайжирсан эсэх, баялгаас олон нийт тэгш хүртэж байгаа эсэх зэрэг үр нөлөөг судлаж, үр дүнг Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулж улмаар олон нийтэд мэдээлэх ажлыг тогтмолжуулах

### **ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, Ажлын албанд**

- ОУИТБС-ын Үндэсний форумыг хоёр жил тутамд зохион байгуулж, өмнөх форумаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг олон талын оролцоотойгоор хэлэлцэн, дүгнэж, ОУИТБС-ын үр нөлөө, хэрэгжилтийг нэмэгдүүлэх
- ОУИТБС-ын цахим тайлагналын системийг олборлох салбарын ил тод байдлын нэг цэгийн үйлчилгээ болгож өргөжүүлэх, бусад эх сурвалжуудыг холбож, нэг цонхны үйлчилгээ болгох
- [www.eitimongolia.mn](http://www.eitimongolia.mn) сайтад аймгуудын дэд зөвлөлийн мэдээллийг аймаг тус бүрээр байршуулж, нэг цэгийн мэдээллийн цаг болгож, харилцан суралцах, мэдээлэл солилцох бололцоог бий болгох
- ОУИТБС-ын тайлан дахь мэдээллийг олон нийтэд мэдээлэх системийг боловсронгуй болгох, загварчлал бий болгох
- Сургагч багш нарыг үргэлжлүүлэн бэлтгэх, оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх
- ОУИТБС-ын хэрэгжилтийн төвлөрлийг сааруулж орон нутаг рүү шилжүүлэх, уул уурхайн холбогдолтой мэдээллийг цаг алдалгүй ил тод, нээлттэй болгож, үйл явцдаа ашиглаж байх орон нутгийн санаачилгыг өрнүүлэх, 2016 оныг дэд зөвлөлийг чадавхжуулах жил болгох, орон нутагт хэрэгжүүлэх аргачлал боловсруулах
- Орон нутгийн хэрэгцээ, онцлогт тохирсон “Бүгдийг бус, чухлыг” онцолсон ОУИТБС-ын орон нутгийн тайлангийн маягт, загвар боловсруулах, тайланг орон нутгийн түвшинд гаргах, олон нийтэд түгээх удирдамж боловсруулах
- Материаллаг байдлын түвшинг эргэн харж ОУИТБС-ын жил бүрийн нэгтгэл тайланд хамрагдах хүрээг шинэчлэн тогтоох
- Тайлангийн мэдээллийг бүх түвшинд ашиглах чадавх олгох, тохиромжтой арга зүй, аргачлалыг боловсруулах, түгээх
- Ажлын албаны бүтэц, орон тоог нэмэгдүүлэх
- Оролцогч талуудын оролцоог үнэлж, талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох, Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, Дэд зөвлөл, Ажлын албаны ажиллах, харилцах, харилцан тайлагнах, хариуцлага тооцох журмыг шинэчлэх, засаглалыг сайжруулах

### **Аймаг, сүмдын Засаг дарга нарт**

- Жил бүрийн ОУИТБС-ын тайлангаа аймгийн Аудитын газраар баталгаажуулан цахим тайлангийн системээр хугацаандаа илгээх
- Аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн бүрэлдэхүүнээ шинэчлэн, иргэд, иргэний нийгмийн тэгш оролцоог хангах, үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Орон нутагтаа жил бүрийн 3 дугаар сард ОУИТБС-ын нээлттэй өдөрлөг зохион байгуулж, өмнөх жилийн ОУИТБС-ын тайлангаа иргэд, олон нийтэд мэдээлж ажиллах
- Дэд зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийн хараат бус, баталгаатай эх үүсвэрийг бүрдүүлж, төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэх бүхий л таатай орчныг бүрдүүлэх

#### **Аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд**

- Аймаг, сумдын ОУИТБС-ын дэд зөвлөлд орж ажиллах идэвхтэй иргэд, иргэний нийгмийн байгууллагуудыг зохион байгуулалтанд оруулж, оролцоог хангах
- Сум, орон нутгийн идэвхтэй иргэд, иргэний нийгмийн олборлох салбарын талаар авахыг хүсч буй мэдээллийн хэрэгцээ шаардлагыг ИТХ-ын төлөөлөгчийг тойрогт нь ажиллуулах замаар тогтмол тодорхойлох
- Малчин өрхөд ОУИТБС-ын мэдээллийг хүргэж ажиллах
- Дэд зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, төсөв, төлөвлөгөөг батлаж өгөх, хяналт тавих
- Дэд зөвлөлийг удирдлага чиг үүргээр хангаж түүний үйл ажиллагааг дэмжиж ажиллах

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын оролцогч талууд